



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/305

Мандалговь

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өндөршил сумын нутагт “Зээгийн хэц” нэртэй XV-48000094 (039/Ду) тоот “Мөрөн говь энерги” ХХК-ний талбай, Гурвансайхан сумын нутагт “Жеммери сүрвей” ХХК-ний “Өндөр элст толгой” нэртэй XV-48000012(040/Ду) тоот, “Талын уул” нэртэй XV-48000014(041/Ду) тоот талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн хугацааг тус тус 2 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тус аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат), Гурвансайхан сумын Засаг дарга (Э.Адьяабаатар), Өндөршил сумын Засаг дарга (У.Алтанхүү) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдэд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг дээрх компанийн захирлуудад тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

483100541